



**ХӨВСГӨЛ АЙМГИЙН
ОРОН НУТГИЙН ӨМЧИЙН ГАЗРЫН ДАРГЫН
ТУШААЛ**

2025 оны 08 сарын 24 өдөр

Дугаар А/45

Мөрөн сум

Хөрөнгө бүртгэх тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 67 дугаар зүйлийн 67.5, аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн 2017 оны 88 дугаар тогтоол, аймгийн Засаг даргын 2017 оны А/32 дугаар захирамж, Барилга байгууламжийг ашиглалтад оруулах комиссын 2024 оны ББКД-67-31/24, ББКД-67-09/24, ББКД-67-27/24, ББКД-67-34/24 дугаар дүгнэлтийг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Аймгийн орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгө оруулалтаар барьж ашиглалтад оруулсан 5 нэрийн нийт **614,595,858.00** (Зургаан зуун арван дөрвөн сая таван зуун ерэн таван мянга найман зуун тавин найман) төгрөгийн үнэ бүхий хөрөнгийг эзэмших байгууллагыг хавсралтаар баталсугай.

2. Хөрөнгө эзэмших байгууллагын дарга нарт дор дурдсан арга хэмжээ авч ажиллахыг даалгасугай.

2.1. Хөрөнгө бүртгэх ажлыг холбогдох хууль тогтоомж, журмын дагуу өмч хамгаалах байнгын зөвлөлийн хяналт дор зохион байгуулж, "Төрийн болон орон нутгийн өмчийн удирдлагыг мэдээлэлжүүлэх систем"-д бүртгэх;

2.2. Хуваарилагдсан хөрөнгийг байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичигт заасны дагуу холбогдох дансанд бүртгэж 2025 оны III улирлын тайланд тусгах, ҮХ-1 баримтыг аймгийн Орон нутгийн өмчийн газарт 2025 оны 09 дүгээр сарын 03-ны өдрийн дотор ирүүлэхийг байгууллагын нягтлан бодогч нарт тус тус даалгасугай.

3. Тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг аймгийн Орон нутгийн өмчийн газрын Өмчийн удирдлага, төлөөлөл хариуцсан мэргэжилтэн (Б.Мөнхзул)-д үүрэг болгосугай.

ДАРГА



Ц.БЭХБАЯР

Аймгийн Орон нутгийн өмчийн газрын 2025 оны 08 дугаар сарын 29-ны өдрийн 14 дугаар тушаалын хавсралт

Орон нутгийн өмчид бүртгэх хөрөнгийн жагсаалт

Аймаг, сумын нэр	Хөрөнгийн нэр	Хэмжих нэгж	Тоо хэмжээ	Балансын анхны өртөг /төг/	Байгуулсан элэгдэл /төг/	Үлдэгдэл үнэ /төг/	Бүртгэх шалтгаан	Эзэмших байгууллага
Мөрөн	Шугам сүлжээний өргөтгөл, трансформатор	ш	1	74,527,182	-	74,527,182	Барилга байгууламжийг ашиглалтад оруулах комиссын 2024 оны 10 дугаар сарын 11-ний өдрийн ББКД-67-31/24 дугаар дүгнэлт	Хөвсгөл Эрчим хүч ХХК
Мөрөн	Ус цэвэршүүлэх төхөөрөмжийн байр	ш	1	236,268,676	-	236,268,676	Барилга байгууламжийг ашиглалтад оруулах комиссын 2024 оны 07 дугаар сарын 02-ны өдрийн ББКД-67-09/24 дүгээр дүгнэлт	Хөвсгөл Ус суваг ХХК
Түнэл сум	Авто машины түр зогсоол	ш	1	99,000,000	-	99,000,000	Барилга байгууламжийг ашиглалтад оруулах комиссын 2024 оны 08 дугаар сарын 10-ны өдрийн ББКД-67-27/24 дүгээр дүгнэлт	Түнэл сумын Засаг даргын Тамгын газар
Баянзүрх сум	Эхийн амрах байр	ш	1	190,000,000	-	190,000,000	Барилга байгууламжийг ашиглалтад оруулах комиссын 2024 оны 11 дүгээр сарын 07-ны өдрийн ББКД-67-34/24 дүгээр дүгнэлт	Баянзүрх сумын Эрүүл мэндийн төв
Баянзүрх сум	Эхийн амрах байрны Цахилгаан зуух	ш	1	14,800,000	-	14,800,000	Барилга байгууламжийг ашиглалтад оруулах комиссын 2024 оны 11 дүгээр сарын 07-ны өдрийн ББКД-67-34/24 дүгээр дүгнэлт	Баянзүрх сумын Эрүүл мэндийн төв
Дүн						614,595,858.00	614,595,858.00	

